

ЧИХ, ХАМАР, ХООЛОЙ СУДЛАЛ МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ТУСГАЙ ШАЛГУУР

Нэг. Ахлах зэрэг хамгаалах тусгай шалгуур:

1. Чих, хамар, хоолойн резидентийн сургалт дүүргэсэн, хүн амд чих хамар хоолойн шинжлэх ухааны онош эмчилгээний тусламжийг аймаг, хот, дүүргийн эмнэлгийн хэмжээнд бүрэн үзүүлэх онол дадлагын мэдлэгтэй, бүтээлтэй байх
2. Чих, хамар, хоолойн эмгэгтэй өвчтөнд чих хамар хоолойн цэвэрлэх төгс хагалгаа(тонзиллэктоми, синустоми, мастойдотоми, конхтоми, полипэктомии, трахеостоми сонсгол тэнцвэрийн паспорт бичих, гэх мэт)-ын онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байна.
3. Ахлах зэргийн эмчийн онол дадлагын шалгалтыг 85%-иас дээш үнэлгээтэй өгсөн байна.
4. ЭМС, БШУС-ын 2003 оны 491/А472 дугаар тушаалын ахлах зэргийн нийтлэг шаардлагыг хангасан байна.

Хоёр. Тэргүүлэх зэрэг хамгаалах тусгай шалгуур:

1. Чих, хамар, хоолойн резидентийн сургалт дүүргэсэн, хүн амд чих хамар хоолойн шинжлэх ухааны онош эмчилгээний тусламжийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн хэмжээнд бүрэн үзүүлэх онол дадлагын мэдлэгтэй, сургалт явуулах чадвартай, бүтээлтэй байна.
2. Чих, хамар, хоолойн эмгэгтэй өвчтөнд чих хамар хоолойн нөхөн сэргээх хагалгаа (тимпаноластика, септоластика, ринопластик, ларинготомии, фаринготомии, чихний өргөтгөсөн хагалгаа. Хүүхдийн чих хамар хоолойн цэвэрлэх мэс засал, СТ, MRI, BERA гэх мэт)-ийн онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байна.
3. Тэргүүлэх зэргийн эмчийн онол дадлагын шалгалтыг 85%-иас дээш үнэлгээтэй өгсөн байна.
4. ЭМС, БШУС-ын 2003 оны 491/А472 дугаар тушаалын тэргүүлэх зэргийн нийтлэг шаардлагыг хангасан байна.

Гурав. Зөвлөх зэрэг хамгаалах тусгай шалгуур:

1. Чих, хамар, хоолойн резидентийн сургалт дүүргэсэн, хүн амд чих хамар хоолойн шинжлэх ухааны онош эмчилгээний тусламжийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн хэмжээнд бүрэн үзүүлэх онол дадлагын мэдлэгтэй, эрдэм шинжилгээний ажил удирдах чадвартай, оюуны өмчтэй байна.
2. Чих, хамар, хоолойн эмгэгтэй өвчтөнд чих хамар хоолойн нөхөн сэргээх бичил мэс засал (гадна, дунд, дотор чихний бичил мэс засал, риносептоластика, ларингоэктоми, ларинготрахеопластика гэх мэт)-ийн онолын мэдлэгтэй буюу хийх ур чадвартай байна.

3. Зөвлөх зэргийн эмчийн онол дадлагын шалгалтыг 85%-иас дээш үнэлгээтэй өгсөн байна.
4. ЭМС, БШУС-ын 2003 оны 491/A472 дугаар тушаалын зөвлөх зэргийн шаардлагыг хангасан байна.